



**ЭРҮҮЛ
МЭНДИЙН ЯАМ**



**МОНГОЛ УЛСЫН ЭРҮҮЛ МЭНДИЙН САЙД
ОРХОН АЙМГИЙН ЗАСАГ ДАРГАТАЙ
2026 ОНД ХАМТРАН АЖИЛЛАХ ГЭРЭЭ**

2026 оны 01 дүгээр сарын ... -ний өдөр
Улаанбаатар хот

**МОНГОЛ УЛСЫН ЭРҮҮЛ МЭНДИЙН САЙД
ОРХОН АЙМГИЙН ЗАСАГ ДАРГАТАЙ
2026 ОНД ХАМТРАН АЖИЛЛАХ ГЭРЭЭ**

Монгол Улсын Төсвийн тухай хуулийн 39 дүгээр зүйлийн 39.1 дэх хэсэг, Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 27 дугаар зүйлийн 27.5.4 дэх заалт, Эрүүл мэндийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.1 дэх заалт, Монгол улсын бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлал, 11.1 дэх хэсэг, Иргэний хуулийн 195-196, 198-202 дахь зүйлийг тус тус үндэслэн:

Нэг талаас Эрүүл мэндийн сайд бөгөөд Эрүүл мэндийн төсвийн ерөнхийлөн захирагч Ж.Чинбүрэн /цаашид "Захиалагч" гэх/,

Нөгөө талаас Орхон аймгийн Засаг дарга Б.Зоригтбаяр /цаашид "Хэрэгжүүлэгч" гэх/ нар энэхүү гэрээг дор дурдсан нөхцөлөөр байгуулав.

Нэг. Нийтлэг үндэслэл

1.1. Гэрээний зорилго нь аймгийн Засаг даргад хууль тогтоомжоор олгосон нийтлэг бүрэн эрхийн хүрээнд Эрүүл мэндийн тухай, Эмнэлгийн тусламж, үйлчилгээний тухай, Нийгмийн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний тухай хууль, Эрүүл мэндийн даатгалын тухай, Эрүүл ахуйн тухай хууль, Эм, эмнэлгийн хэрэгслийн тухай хууль, тогтоомжийг хэрэгжүүлэхтэй холбогдуулан УИХ, Засгийн газар, Эрүүл мэндийн яамнаас гаргасан шийдвэрийг хэрэгжүүлэх, харьяалах нутаг дэвсгэрийнхээ хүн амд үзүүлэх эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний тэгш хүртээмжтэй, чанартай, шуурхай байдлыг хангахад оршино.

1.2. Энэхүү гэрээтэй холбогдох бусад асуудлыг Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хууль, Төсвийн тухай, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай, Монгол Улсын 2026 оны төсвийн тухай хууль болон бусад холбогдох хууль тогтоомжоор тус тус зохицуулна.

1.3. Гэрээг хоёр хувь үйлдэв.

Хоёр. Захиалагчийн эрх, үүрэг

2.1. Захиалагч нь эрүүл мэндийн байгууллагуудаас үзүүлэх тусламж, үйлчилгээний санхүүжилтийг дараах байдлаар санхүүжүүлнэ. Үүнд:

2.1.1. Аймгийн Эрүүл мэндийн газар, Зоонозын өвчин судлалын төвийн үйл ажиллагааны санхүүжилтийг батлагдсан төсвийн дагуу улсын төсвөөс шууд санхүүжүүлнэ.

2.1.2. Эрүүл мэндийн даатгалын сангаас анхан шатны эрүүл мэндийн байгууллагын санхүүжилтийг нэг иргэнээр болон тусламж, үйлчилгээний чанар үр дүнд суурилсан гүйцэтгэлээр, лавлагаа шатлалын эрүүл мэндийн байгууллагын санхүүжилтийг тусламж, үйлчилгээний чанар, үр дүнд суурилсан гүйцэтгэлээр тус тус санхүүжүүлнэ.

2.2. Хөрөнгө оруулалтын санхүүжилтийн гүйцэтгэгчийг Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн дагуу сонгон шалгаруулж, гүйцэтгэлээр санхүүжүүлнэ.

2.3. Нийгмийн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний тухай хуулийг хэрэгжүүлэхэд мэргэжил арга зүйн дэмжлэг үзүүлж ажиллана.

2.4. Хүн амыг өвчнөөс урьдчилан сэргийлэх, өвчнийг эрт илрүүлэх үйл ажиллагааг тэргүүлэх чиглэл болгон ураг, нярайн эрт илрүүлэг, сургуульд суурилсан эрт илрүүлгийг үндэсний хэмжээнд хэрэгжүүлж, ажил олгогчийн зүгээс зохион байгуулах эрүүл мэндийн урьдчилсан болон хугацаат үзлэг, хавдрын эрт илрүүлэг үзлэгийг орон нутагт хэрэгжүүлэхэд мэргэжил арга зүйн удирдлагаар ханган хамтран ажиллана.

2.5. Нийгмийн эрүүл мэндийн ноцтой байдал, халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх, халдварын үеийн тусламж, үйлчилгээний тасралтгүй байдал, хариу арга хэмжээний чадавхийг бэхжүүлэхэд салбар хоорондын уялдааг ханган мэргэжлийн удирдлагаар тухай бүрт ханган ажиллана.

2.6. Нийслэл хотноо төвлөрч иргэдэд хүлээгдэл үүсгэж байгаа төрөлжсөн мэргэшлийн тусламж үйлчилгээний төвлөрлийг сааруулах бодлогын хүрээнд орон нутгийн эрүүл мэндийн байгууллагын хүний нөөц, техник тоног төхөөрөмжийг чадавхийг бэхжүүлэх арга хэмжээг хэрэгжүүлнэ.

2.7. Эрүүл мэндийн тусламж үйлчилгээнд нэн шаардлагатай эм, эмнэлгийн хэрэгсэл, багаж, тоног төхөөрөмжийн нөөц, ашиглалтын мэдээллийн нэгдсэн санг ашиглалтад оруулж эм, эмнэлгийн хэрэгслийн хангамжийн тасралтгүй байдлыг хангахад дэмжлэг үзүүлж хяналт тавьж ажиллана.

2.8. Дутагдалтай байгаа эмнэлгийн мэргэжилтнийг орон нутагт нь бэлтгэх энэ чиглэлээр орон нутгийн нэгдсэн эмнэлгийг түшиглэн төгсөлтийн дараах сургалт эрхлэх үйл ажиллагааг мэргэжил арга зүйн удирдлагаар хангана.

2.9. Салбарын хүний нөөцийн төгсөлтийн дараах сургалтын тэргүүлэх чиглэлийг баталж, тэргүүлэх чиглэлийн хүрээнд эрүүл мэндийг ажилтныг гадаад, дотоодын урт, богино хугацааны сургалтад хамруулах арга хэмжээг авч хэрэгжүүлнэ.

2.10. Салбарт албан бичиг, өргөдөл гомдлын мэдээллийг бүрэн цахимжуулах бодлого хэрэгжүүлж албан бичиг, өргөдөл, гомдол хүлээн авах, шийдвэрлэлтийн явцын хяналтыг тухай бүрт цахимаар (Able) хянан ажиллана.

2.11. Мэдээллийн ил тод байдлыг хангах, нотолгоонд суурилсан шийдвэр гаргалтыг дэмжих зорилгоор төрөлжсөн мэдээний сан (Dashboard) үүсгэн мэдээллийг ил тод байршуулан шийдвэр гаргалтад ашиглах нөхцөлийг бүрдүүлнэ.

2.12. Аймаг, орон нутагт хэрэгжүүлж байгаа эрүүл мэндийн чиглэлийн төсөл, хөтөлбөр, үйл ажиллагаа, санал санаачилгыг хууль эрх зүйн хүрээнд бүрэн дэмжиж ажиллана.

Гурав. Хэрэгжүүлэгчийн эрх, үүрэг

3.1. Хэрэгжүүлэгч нь Эрүүл мэндийн тухай хуульд заасан бүрэн эрхийн хүрээнд "Алсын хараа-2050" Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого, Монгол Улсыг 2026-2030 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл, Монгол Улсын Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөр, Монгол Улсын хөгжлийн 2026 оны төлөвлөгөөнд тусгагдсан үйл ажиллагааг орон нутгийн хэмжээнд хэрэгжүүлэн гэрээний үр дүнг Захиалагчийн өмнө хариуцна.

3.2. Төрийн албаны тухай хуулийн 53 дугаар зүйл, Засгийн газрын 2020 оны 216 дугаар тогтоолын дагуу харьяалах Эрүүл мэндийн байгууллагын дунд хугацааны бодлогын баримт бичиг Стратеги төлөвлөгөөний хэрэгжилтийг хангахад дэмжлэг үзүүлж, хэрэгжилтэд хяналт тавьж ажиллана.

3.3. Харьяалах нутаг дэвсгэрийн эрүүл мэндийн байгууллагын удирдах ажилтаныг хууль журмын дагуу сонгон шалгаруулалтаар томилж, хүний нөөцийн тогтвортой байдлыг хангана.

3.4. Өөрийн харьяа нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулж байгаа эрүүл мэндийн байгууллагын хүний нөөцийн хангалт, тогтвортой байдалд анхаарлаа хандуулж тэдний нийгмийн баталгаа, ажиллах нөхцөлийг дэмжиж ажиллана.

3.5. Эрүүл мэндийн байгууллагын барилгыг шинээр ашиглалтад оруулсан тохиолдолд хуучин барилгыг эрүүл мэндийн тусламж, үйлчилгээнд ашиглахгүй байх, Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 20.1.18, 21.1.16 дахь заалтын дагуу төрийн өмчит эрүүл мэндийн байгууллагын барилга байгууламж, ашиглалт, засвар үйлчилгээний ажлын санхүүжилтийг бүрэн шийдвэрлэн ажиллана.

3.6. Эмнэлгийн тусламж, үйлчилгээтэй холбоотойгоор үүссэн өр, авлагыг барагдуулан шинээр өр үүсгэхгүй, санхүүгийн сахилга баттай ажиллах.

3.7. Эрүүл мэндийн даатгалын хамралтыг нэмэгдүүлэх ялангуяа ядуу, эмзэг бүлгийн иргэд, малчид, хувиараа хөдөлмөр эрхлэгч, их дээд сургууль, коллеж, мэргэжлийн сургалт үйлдвэрийн төвийн суралцагчдын хамрагдалтыг нэмэгдүүлэх, энэ чиглэлээр орон нутгийн удирдлага, иргэдтэй хамтран ажиллаж эрүүл мэндийн даатгалын талаар мэдээлэл, сурталчилгааны ажил тогтмол зохион байгуулна.

3.8. Харьяа нутаг дэвсгэрийн эрүүл мэндийн байгууллагын бүтэц, зохион байгуулалт, өмчийн харьяаллыг өөрчлөх, төрийн өмчит байгууллага шинээр байгуулах, хүчин чадлыг нэмэгдүүлэх тохиолдолд Захиалагч талтай харилцан зөвшилцсөний үндсэн дээр шийдвэрлэнэ.

3.9. Төрийн бүх шатны байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит, төрийн болон орон нутгийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн авлигатай тэмцэх төлөвлөгөөний хэрэгжилтийг бүрэн хангаж ажиллана.

3.10. Шүгэл үлээхийг дэмжих зорилгоор мэдээлэл өгөх суваг, хамгаалалтын арга хэлбэр, ач холбогдлын талаар олон нийтэд сурталчилна.

3.11. Харьяа нутаг дэвсгэрийн хүн амын эрүүл мэндийг хамгаалах, дэмжих, өвчлөлийг хянах, сэргийлэх, эрүүл мэндийн аюулгүй байдлыг хангах чиглэлээр нийгмийн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний дараах үйл ажиллагааг ханган ажиллана. Үүнд:

3.11.1. Нийгмийн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний тухай хуулийн хэрэгжилтийг хангах, аймгийн эрүүл мэндийн газрын харьяанд Нийгмийн эрүүл мэндийн бие даасан төв байгуулах бэлтгэл ажлыг хангах, хуулийг сурталчлан таниулах үйл ажиллагааг өргөнөөр зохион байгуулна.

3.11.2. Хүн амын дунд эрүүл амьдралын хэв маягийг төлөвшүүлэх чиглэлээр сургалт, сурталчилгаа, нөлөөллийн арга хэмжээг иргэн, аж ахуйн нэгж байгууллага, төрийн болон төрийн бус байгууллагатай хамтран тогтмол зохион байгуулна.

3.11.3. Зорилтот бүлэгт насны ангиллын дагуу зохион байгуулж байгаа "Урьдчилан сэргийлэх, эрт илрүүлэх үзлэг, оношилгоо" арга хэмжээнд өөрийн харьяа нутаг дэвсгэрийн хүн амыг бүрэн хамруулж, иргэд болон ажил олгогчдыг идэвхжүүлэх, энэ чиглэлээр төрийн болон төрийн бус байгууллагын оролцоог нэмэгдүүлэн санаачилгатай ажиллана. (Ураг, нярайн эрт илрүүлэг, сургуульд суурилсан эрт илрүүлгийг үндэсний хэмжээнд хэрэгжүүлж, ажил олгогчийн зүгээс зохион байгуулах эрүүл мэндийн урьдчилсан болон хугацаат үзлэг, хавдрын эрт илрүүлэг)

3.11.4. Үндэсний хэмжээнд эрүүл мэндийн чиглэлээр хэрэгжиж байгаа 18 арга хэмжээний төлөвлөгөөний хэрэгжилтийг ханган ажиллана. Хавсралт 4.

3.11.5. Алслагдсан сумдад амны хөндийн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээг өргөжүүлэн үзлэг оношилгоо, эмчилгээний явуулын баг ажиллуулан урьдчилан сэргийлэх, эмчлэн эрүүлжүүлэх арга хэмжээг санхүүжилтийн хувьд дэмжлэг үзүүлэн ажиллана.

3.11.6. Анхан шатны эрүүл мэндийн байгууллагад халдварт бус өвчин, ялангуяа дундаа зүрх судасны өвчнөөс сэргийлэх, хянах нэн шаардлагатай тусламж, үйлчилгээний багц МонПЭН болон мобайл технологи ашиглан тусламж, үйлчилгээ үзүүлж байгаа байдалд хяналт тавьж, шаардлагатай дэмжлэг үзүүлж ажиллана.

3.11.7. Сэтгэцийн эрүүл мэнд, ялангуяа хүүхэд, өсвөр үеийнхэнд сэтгэлзүйн тусламж, үйлчилгээ үзүүлэх, сэтгэцийн эрүүл мэндийг дэмжих, хамгаалах, архи, тамхи, утаат болон электрон тамхи, мансууруулах, сэтгэцэд нөлөөт бодисын хор хөнөөлийн талаарх мэдлэг олгох, хэрэглээг бууруулах, урьдчилан сэргийлэх болон осол, гэмтлээс сэргийлэх (ахуйн орчны осол гэмтэл, уналт, автотээврийн гэх мэт)-д анхаарч салбар дундын хамтын ажиллагааг өргөжүүлнэ.

3.11.8. Хүн амын дунд зонхилон тохиолдож байгаа сүрьеэ, бэлгийн замаар дамжих халдварт өвчнийг тандах, илрүүлэх, урьдчилан сэргийлэх үзлэгт зорилтот бүлгийг хамруулах арга хэмжээг төрийн болон төрийн бус байгууллага, ажил олгогчидтой хамтран зохион байгуулж, санхүүжилтэд дэмжлэг үзүүлэх, эмчилгээнд хамрагдалт, эмчилгээний үр дүнд улирал бүр хянана.

3.11.9. Дархлаажуулалтын ач холбогдлыг төрийн болон төрийн бус байгууллага, аж ахуйн нэгжтэй хамтран иргэдэд сурталчлан таниулж, сургуульд суурилсан дархлаажуулалтыг зохион байгуулахад эрүүл мэндийн байгууллага болон боловсролын байгууллага хамтран ажиллахад дэмжлэг үзүүлэн дархлаажуулалтын хамралтыг орон нутгийн түвшинд нэмэгдүүлнэ.

3.11.10. Эхийн сүүгээр хооллолтыг дэмжих, нялх, балчир хүүхдийг эрүүл, аюулгүй хүнсээр тасралтгүй хангах, хүнсний чанар, аюулгүй байдлын хяналтыг хэрэгжүүлэх хүрээнд Нялх, балчир хүүхдийн хүнсний тухай хуулийн биелэлтийг хангаж, хэрэгжилтэд тогтмол хяналт тавьж ажиллана.

3.11.11. Хөгжлийн бэрхшээлтэй иргэн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ авах дэд бүтцийг сайжруулан, тэдний мэдээлэл авах эрхийг хангах зорилгоор шат, баррель үсэг, зам, дуут санамжийг нэвтрүүлэлтэд хяналт тавьж ажиллана.

3.11.12. Эрүүл ахуйн тухай хуулийн хэрэгжилтийг ханган эрүүл мэндийн байгууллагыг сайжруулсан ариун цэврийн байгууламжтай болоход дэмжлэг үзүүлж,

1-2 сумын эрүүл мэндийн төвийн ариун цэврийн байгууламжийг стандартын дагуу шинэчлэн байгуулна.

3.11.13. Алслагдсан эрүүл мэндийн төвүүдэд төр, хувийн хэвшлийн түншлэлийн хүрээнд нарны болон газрын гүний сэргээгдэх эрчим хүчийг ашиглан түүхий нүүрсний хэрэглээг 1-3 сумын эрүүл мэндийн төвд зогсооно.

3.11.14. Усны тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1.1, 12.1.4, Эрүүл ахуйн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.3, 4.1.5, Хот, суурины ус хангамж, ариутгах татуургын ашиглалтын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.2 дэх хэсэгт заасныг үндэслэн харьяалах нутаг дэвсгэрийнхээ хүн амыг чанар, аюулгүй байдлын шаардлага хангасан үндны усаар тогтвортой, хүртээмжтэй хангах, ус хангамж, ариун цэврийн байгууламжийн аюулгүй байдлын төлөвлөгөөг хэрэгжүүлнэ.

3.11.15. Эрүүл мэндийн байгууллагыг уур амьсгалын өөрчлөлтөд тэсвэртэй, цахилгааны тасралтгүй эх үүсвэрээр хангах, цахилгаан эрчим хүчний доголдлоос эмнэлгийн тоног, төхөөрөмж гэмтэх, цахилгааны богино холбоо үүсэх эрсдэлээс сэргийлж дотоод хяналтыг тогтмолжуулж, цахилгааны нөөц эх үүсвэрийн бэлэн байдлыг ханган ажиллана.

3.11.16. Эрүүл ахуйн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.3-т "Барилга байгууламж барих газрын байршил тогтоох, барилгын зураг төсөл зохиох, барилга барих, ашиглалтад оруулах, өргөтгөх, зориулалтыг нь өөрчлөхөд эрүүл мэндийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаар эрүүл ахуйн дүгнэлт гаргуулна" гэж заасны дагуу газар олгохтой холбоотой дүрэм, журамд өөрчлөлт оруулах замаар барилга байгууламж барих газрын байршил тогтооход эрүүл ахуйн дүгнэлт гаргуулж байх нөхцөлийг бүрдүүлэхэд анхааран ажиллана.

3.12. Харьяа нутаг дэвсгэрийн хүн амд үзүүлэх эмнэлгийн тусламж, үйлчилгээний чанар, хүрээмж, аюулгүй байдлыг хангах чиглэлээр дараах үйл ажиллагааг хэрэгжүүлэн ажиллана. Үүнд:

3.12.1. Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээнд "Эрүүл мэндийн үйлчилгээнд тавих шаардлага" MNS 7014:2023 стандартын үнэлгээ хийж үнэлгээнээс гарсан дүгнэлт, зөвлөмжийн хэрэгжилтэд хяналт тавьж дэмжлэг үзүүлж ажиллана.

3.12.2. Анхан шатны тусламж үйлчилгээ үзүүлэгч өрх, сумын эрүүл мэндийн төвөөс үзүүлэх гэрийн эргэлт, архаг өвчний хяналтын үзлэгийг чанаржуулж, гүйцэтгэлд хяналт тавьж, орон нутагт түр оршин суугч, явуулын иргэдэд эрүүл мэндийн тусламж, үйлчилгээг харьяалал харгалзахгүй түргэн шуурхай үзүүлнэ.

3.12.3. Өрх, сумын эрүүл мэндийн төвд 9 сар, 18 сар, 36 сартай хүүхдийн эрүүл мэнд, хөгжлийн цогц үзлэг тогтмол зохион байгуулж, хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн сэргээн засах, хөдөлгөөн засах тусламж, үйлчилгээг өргөжүүлж энэ чиглэлийн тусламж, үйлчилгээ үзүүлж байгаа эрүүл мэндийн байгууллагыг дэмжиж ажиллана.

3.12.4. Өрхийн эрүүл мэндийн төвтэй байгуулсан гэрээний үүргээ биелүүлж үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлж ажиллана.

3.12.5. Баг, сумын эрүүл мэндийн төвийн эмч нарыг дулаан хувцсаар хангах, сумын эрүүл мэндийн төвийн автомашины засвар үйлчилгээг шийдвэрлэн ажиллана.

3.12.6. Жирэмсний эрт үеийн хяналтын хамралтыг нэмэгдүүлэн жирэмсэн үеийн гурвалсан халдвар (ХДХВ, тэмбүү, гепатитын В, С, вирус)-ын илрүүлэг шинжилгээний хамрагдалт, тэмбүүтэй жирэмсэн эмэгтэйн эмчилгээ, эмчилгээний дараах хяналт, бэлгийн хавьтагчийн илрүүлэлт, оношилгоо, эмчилгээний байдалд байнга хяналт тавьж төрөлхийн тэмбүүгийн тохиолдол гаргахгүй ажиллана.

3.12.7. Жирэмсэн эмэгтэйн амь насанд ноцтой хүндрэл гарч зайлшгүй тээвэрлэх шаардлага үүссэн тохиолдолд онгоц болон бусад тээврийн хэрэгслийн зардлыг Засаг даргын нөөц хөрөнгөөс гарган дэмжлэг үзүүлнэ.

3.12.8. Эх, нялхас, 5 хүртэлх насны хүүхдийн эндэгдэл, ялангуяа сэргийлж болох эндэгдлийг тууштай бууруулах чиглэлээр тэгш, хүртээмжтэй, чанартай тусламж, үйлчилгээг орон нутгийн түвшинд зохион байгуулж, эх, хүүхдийн эндэгдэлд судалгаа тогтмол хийж, хариу арга хэмжээ хэрэгжүүлэн үр дүнг тооцон ажиллана.

3.12.9. Анхан шатны эрүүл мэндийн байгууллагуудын эмнэлгийн тусламж, үйлчилгээний чанар аюулгүй байдал, эрсдэлийн удирдлагын тогтолцоог хөгжүүлэн дэмжиж эмнэлгийн тусламж үйлчилгээтэй холбоотой халдвараас сэргийлэх, тандалт судалгаа хийх зэрэг өвчтөний аюулгүй байдлыг хамгаалахад чиглэсэн арга хэмжээний тасралтгүй байдалд хяналт тавьж ажиллана.

3.12.10. Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар нийлүүлэгдсэн томоохон тоног төхөөрөмжүүд болох Компьютерт томографын аппарат, Ангиографын аппарат, Хүчилтөрөгчийн бэсрэг үйлдвэр зэргийн засвар үйлчилгээ, сэлбэг хэрэгсэлд шаардлагатай төсвийг шийдвэрлэж, ашиглалт, аюулгүй ажиллагаанд байнгын хяналт тавьж, хүний нөөцийн чадавхыг бэхжүүлэхэд дэмжлэг үзүүлж ажиллана.

3.12.11. "Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль"-ийн 36.1.2-т заасны дагуу Төрийн өмчийн эрүүл мэндийн байгууллагаас үзүүлэх тусламж, үйлчилгээнд хэрэглэх эм, эмнэлгийн хэрэгслийн тооцоо, судалгааг гарган Эм, эмнэлгийн хэрэгслийн хяналт, зохицуулалтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагад тогтоосон хугацаанд хүргүүлнэ.

3.12.12. Иргэдийн дунд сайн дурын авлагагүй донорын эгнээг өргөжүүлж аюулгүй цус, цусан бүтээгдэхүүний бэлдмэлийн хангамжийг нэмэгдүүлнэ.

3.12.13. Алслагдсан сумдад жирэмсэн эх, хүүхэд, нөхөн үржихүйн болон амны хөндийн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээг өргөжүүлэн үзлэг, оношилгоо, эмчилгээний явуулын баг ажиллуулан урьдчилан сэргийлэх, эмчлэн эрүүлжүүлэх арга хэмжээнд санхүүгийн дэмжлэг үзүүлж зохион байгуулан ажиллана.

3.12.14. Харьяа нутаг дэвсгэрийн эрүүл мэндийн байгууллагад зайлшгүй шаардлагатай (түргэн тусламжийн автомашин, тоног төхөөрөмж, барилга, засвар үйлчилгээний зардал) бусад дэмжлэгийг (Багийн эмчийн унааны шатахууны зардал) Засаг даргын нөөц сан, Орон нутгийн төсвийн хөрөнгө, Орон нутгийн хөгжлийн сангаас шийдвэрлэх арга хэмжээ авч ажиллана.

3.13. Эрүүл мэндийн мэдээлэл технологи, цахим шилжилтийн чиглэлээр:

3.13.1. Эрүүл мэндийн байгууллагад мэдээлэл, технологийн техник хангамж, сүлжээ, программ хангамжийн дэд бүтцийг өргөжүүлэн бүх эрүүл мэндийн байгууллагыг өндөр хурдны интернэт сүлжээнд холбоно.

3.13.2. Эрүүл мэндийн байгууллага нь онц чухал мэдээллийн дэд бүтэцтэй байгууллага гэж Кибер аюулгүй байдлын тухай хуулийн 19.1.3 дахь заасны дагуу эрүүл мэндийн мэдээллийн аюулгүй байдал, мэдээллийн системийн өдөр тутмын үйл ажиллагааг явуулахад шаардлагатай сервер, тоног төхөөрөмжөөр ханган байнгын хяналт тавьж эрсдэлийн үнэлгээ хийлгэж зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллана.

3.13.3. Кибер аюулгүй байдлын сургалтад Лавлагаа шатлалын эрүүл мэндийн байгууллагын мэдээллийн технологийн ажилтан, статистик мэдээллийн ажилчдыг улирал бүр хамруулна.

3.13.4. Алсын зайн анагаах ухаан, телемедицины үйл ажиллагааны тасралтгүй байдлыг хангах тоног, төхөөрөмж хурдны интернэтээр ханга ажиллана.

3.13.5. Эм, эмнэлгийн хэрэгслийн нөөц бүрдүүлэх, тусламж, үйлчилгээний тасралтгүй байдлыг хангах, хүн амд эмийн зохистой хэрэглээг төлөвшүүлэх, эм, эмнэлгийн хэрэгсэл, эрүүл мэндийн нэмэлт бүтээгдэхүүний мэдээллийн сан бүрдүүлэх, мэдээ, мэдээллийн шуурхай, аюулгүй байдлыг ханган ажиллана.

3.14. Хүний нөөцийн чиглэлээр:

3.14.1. Эрүүл мэндийн ажилтны нийгмийн баталгааг сайжруулан, орон нутагт тогтвор суурьшилтай ажиллуулах чиглэлээр орон сууц, гэрээр хангах, малжуулах арга хэмжээ хэрэгжүүлнэ.

3.14.2. Хөдөлмөрийн тухай хуулийн 145.4-т заалтын дагуу ахмад настныг ажлын байраар ханган, хүний нөөцийн дутагдалтай байдлыг шийдвэрлэн ажиллана.

3.14.3. Эрүүл мэндийн байгууллагын ажилтнуудыг ажиллангаа суралцан мэргэжил дээшлүүлэх, үндсэн болон төрөлжсөн мэргэшил эзэмших, мэдлэг, ур чадварыг тасралтгүй хөгжүүлэхэд чиглэсэн гадаад, дотоод сургалтад хамруулах болон эрүүл мэндийн удирдах ажилтнуудыг үе шаттайгаар бэлтгэн ур чадварыг дээшлүүлэхэд дэмжлэг үзүүлнэ.

3.14.4. Аймгийн Нэгдсэн эмнэлгийг ерөнхий мэргэшил судлалаар сургалт эрхлэх байгууллага болгон бэлтгэж, шаардлагатай хөрөнгө оруулалтыг шийдвэрлэж, орон нутгийн эрүүл мэндийн байгууллагад шаардлагатай хүний нөөцийг мэргэшүүлэн бэлтгэх арга хэмжээг хамтран хэрэгжүүлж дэмжлэг үзүүлнэ.

3.14.5. Нийгмийн эрүүл мэндийн төв, анхан шатны эрүүл мэндийн байгууллагуудыг нийгмийн эрүүл мэндийн мэргэжилтэнээр хангах, тэднийг сурахад дэмжлэг үзүүлнэ.

3.15. Бусад үйл ажиллагааны чиглэлээр:

3.15.1. Төлөвлөгөөт болон төлөвлөгөөт бус, урьдчилан сэргийлэх хяналт шалгалтын дүнг Засаг даргын зөвлөлийн хурлаар хэлэлцэн харьяалах нутаг

дэвсгэрт эрүүл мэндийн чиглэлээр илэрч буй зөрчлийг арилгуулах, үүсэж болзошгүй эрсдэлээс сэргийлэх, эрсдэлийг бууруулах чиглэлээр арга хэмжээ авч ажиллана.

3.15.2. Хяналт үнэлгээний үндэсний хорооны 2024 оны 02 дугаар тогтоолоор батлагдсан Салбарын хяналтын 2026 онд хэрэгжүүлэх хяналт шалгалтын төлөвлөгөө, ЭМЯ-ны Салбарын хяналтын газрын 2026 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөний хэрэгжилтийг харьяалах нутаг дэвсгэртээ хангуулж, хяналт шалгалтын дүнг Засаг даргын зөвлөлийн хурлаар хэлэлцэж, харьяалах нутаг дэвсгэртээ илэрч буй зөрчил дутагдлыг арилгуулах, үүсэж болзошгүй эрсдэлээс урьдчилан сэргийлэх, эрсдэлийг бууруулах чиглэлээр бодлого зохицуулалтын арга хэмжээ авч ажиллана.

3.15.3. Үндэсний хэмжээнд эрүүл мэндийн чиглэлээр гэрээний хугацаанд одоо хэрэгжиж байгаа болон шинээр батлагдсан төлөвлөгөө, хөтөлбөр, арга хэмжээг орон нутгийн түвшинд хэрэгжүүлж, салбар дундын уялдааг ханган хамтарч ажиллана.

3.15.4. Засаг даргын зөвлөлийн хурлаар дараах асуудлын хэрэгжилтийг хэлэлцэн тулгамдаж буй асуудлыг шийдвэрлэж санал санаачилгатай ажиллана. Үүнд:

- Үндэсний хэмжээнд эрүүл мэндийн чиглэлээр гэрээний хугацаанд одоо хэрэгжиж байгаа болон шинээр батлагдсан төлөвлөгөө, хөтөлбөр, арга хэмжээг
- Эрт илрүүлэх үзлэг, шинжилгээ, оношилгооны явц, үр дүн;
- Цахимжилт, Кибер аюулгүй байдал, мэдээллийн аюулгүй байдал;
- Хүний нөөцийн тогтвор суурьшил, нийгмийн баталгааны дэмжих чиглэлээр хэрэгжүүлж буй арга хэмжээ;
- "Эрүүл мэндийн үйлчилгээнд тавих шаардлага" MNS 7014:2023 стандартын үнэлгээний дүнг хэлэлцэх;
- Аймгийн эрүүл мэндийн газрын харьяанд байгуулах Нийгмийн эрүүл мэндийн төв байгуулах бэлтгэл ажлын төлөвлөгөө хэрэгжилт;
- Эрүүл ахуйн тухай хуулийн хэрэгжилт;
- Өрхийн эрүүл мэндийн төвтэй байгуулсан гэрээний үүргийн хэрэгжилт;
- Аймаг, орон нутгийн онцлогоос шалтгаалсан бусад тулгамдсан асуудлууд.

Дөрөв. Гэрээний хэрэгжилт, гэрээний тайлагналт

Аймгийн Эрүүл мэндийн газрын даргатай гэрээ байгуулахад энэхүү гэрээ болон Эрүүл мэндийн газрын саналыг харгалзана.

4.1. Үйл ажиллагааны төсвийн зарлагын хэмнэлт, зардлын бүлэг хооронд шилжүүлэн зарцуулах зохицуулалтыг Төсвийн тухай хуулийн 42, 45, 46 дугаар зүйл, заалтын дагуу Захиалагчид бичгээр хүсэлт гаргаж шийдвэрлүүлнэ.

4.2. Хэрэгжүүлэгч нь Захиалагчийн үйл ажиллагаатай уялдуулан жилийн санхүүжилтийн төсвийн төсөлд оруулах хөрөнгө оруулалтын талаар 2 тал харилцан тохиролцон аливаа нэг давхцал үүсгэхгүй байна.

4.3. Эрүүл мэндийн байгууллагуудын өр, авлагын байдалд хяналт тавин ажиллаж Төсвийн тухай хуулийн 6.2, 6.3, 6.4 болон 16.5.2, 16.5.3, 16.5.5, 57.5-д

заасныг мөрдлөг болгон өр, авлага үүсгэсэн орон нутгийн эрүүл мэндийн байгууллагын Ерөнхий менежертэй хариуцлага тооцож тооцсон талаарх тайлангаа тухай бүрд нь Төсвийн ерөнхийлөн захирагчид хүргүүлнэ.

4.4. Төсвийн тухай хуулийн 8.9.2 дахь заалтын дагуу орон нутаг дахь эрүүл мэндийн байгууллагуудын төсвийн гүйцэтгэл, санхүүгийн жилийн тайланг Эрүүл мэндийн газраар нэгтгэн гаргуулж, аудит хийлгэн дараа оны 03 дугаар сарын 05-ны өдрийн дотор Төсвийн ерөнхийлөн захирагчид ирүүлнэ.

4.5. Төсвийн тухай хуулиар Эрүүл мэндийн сайдын багцад батлагдсан хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний санхүүжилтийг Эрүүл мэндийн яамны хөрөнгө оруулалтын дансаар дамжуулж санхүүжүүлнэ.

4.6. Эрүүл мэндийн сайдын багцаас аймгийн Засаг дарга нарт эрх шилжсэн ажлын явцын мэдээллийг сар бүр Эрүүл мэндийн яаманд дараа сарын 05-ны дотор хүргүүлж байна.

4.7. Хэрэгжүүлэгч нь хагас жилээр эрүүл мэндийн тусламж үйлчилгээний чанарын үзүүлэлтийн биелэлтийг 06 дугаар сарын 15-ны дотор; бүтэн жилээр гэрээний Гуравдугаар зүйлд тусгагдсан үйл ажиллагаа тус бүрийн биелэлт, эрүүл мэндийн тусламж үйлчилгээний чанарын үзүүлэлтийн биелэлт, төсвийн гүйцэтгэл, хөрөнгө оруулалтын төсөл арга хэмжээний хэрэгжилтийг жилийн эцсийн байдлаар дараа оны 01 дүгээр сарын 15-ны дотор Төсвийн ерөнхийлөн захирагчид ирүүлнэ.

4.8. Аймгийн Засаг даргын Тамгын газрын санхүүгийн хяналт шалгалт, аудитын нэгж нь харьяа нэгдсэн эмнэлэг, өрх, сумын Эрүүл мэндийн төв, бусад харьяа эрүүл мэндийн байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд эрсдэлд суурилсан хяналт шалгалтыг холбогдох хууль, журмын дагуу гүйцэтгэж, тайлангаа Эрүүл мэндийн яамны дотоод аудитын үйл ажиллагааг хариуцсан газарт тухайн жилийн 12 дугаар сарын 25-ны дотор хүргүүлнэ.

Тав. Улсын төсөв болон Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжүүлэх

5.1. Эрүүл мэндийн газрын санхүүжилтийг энэхүү гэрээний 2 дугаар хавсралтад тусгагдсан төсөв болон Сангийн сайдын баталсан төсвийн сар, улирлын хуваарийн дагуу Төрийн сангийн нэгдсэн дансаар дамжуулан олгоно.

5.2. Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний гүйцэтгэлээр санхүүжих байгууллагуудын санхүүжилтийг Эрүүл мэндийн даатгалын байгууллагатай байгуулсан Тусламж, үйлчилгээ худалдан авах гэрээний дагуу Эрүүл мэндийн даатгалын сангаар дамжуулан санхүүжүүлнэ.

5.3. Сангийн яамны Төрийн сангийн газар нь санхүүжилтийн төлбөрийг Хэрэгжүүлэгчийн захиран зарцуулах эрх бүхий Төрийн сангийн дансанд сар бүрийн тогтсон хуваарьт өдрүүдэд багтаан шилжүүлэх үүрэг хүлээнэ.

Зургаа. Гэрээний хэрэгжилтийг дүгнэх шалгуур үзүүлэлт, үнэлэх

6.1. Харьяа нутаг дэвсгэрийн хүн амын эрүүл мэндийг хамгаалах, дэмжих чиг үүргийг Засгийн газрын өмнө төлөөлөн хэрэгжүүлэх, хөтөлбөр, арга хэмжээ, түүнд шаардагдах урсгал зардал болон бусад зардал, хүрэх үр дүнгийн шалгуур үзүүлэлт тус бүрээр баталж үнэлнэ. Үүнд:

6.1.1. Эрүүл мэндийн шалгуур үзүүлэлт;

6.1.2. Аймгийн Эрүүл мэндийн газрын 2026 оны төсөв;

6.1.3. 2026 оны хөрөнгө оруулалт;

6.2. Гэрээний хэрэгжилтийг Төсвийн тухай хууль, Эрүүл мэндийн тухай хууль болон холбогдох бусад хууль, тогтоомж, "Бодлогын баримт бичгийн хэрэгжилт болон захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам"-ыг удирдлага болгон, хагас жилд үр дүнгийн шалгуур үзүүлэлтээр, бүтэн жилд гэрээний заалт бүрийн хэрэгжилт, гүйцэтгэлийн болон үр дүнгийн шалгуур үзүүлэлтээр үнэлнэ.

6.3. Захиалагч нь гэрээний үүргийн биелэлтэд үнэлгээ хийж, үнэлгээний дүнг Засгийн газрын Хэрэг эрхлэх газарт 2026 оны 03 дугаар сарын 01-ний дотор хүргүүлнэ.

Долоо. Гэрээний хугацаа

7.1. Энэхүү гэрээний хүчинтэй хугацаа 2026 оны төсвийн жилийн хүрээнд үйлчилнэ.

Найм. Гэрээний үнэ

8.1. Энэхүү гэрээний нийт төсөвт өртөг **2,504,967.4** мянган төгрөг болон гүйцэтгэлээр санхүүжих төсөв байна.

8.2. Хэрэгжүүлэгчийн хуулиар олгосон бүрэн эрхийн хүрээнд орон нутгийн төсөв, хөгжлийн сан болон бусад эх үүсвэрээс санхүүжилтийг нэмэгдүүлж болно.

Ес. Гэрээнд нэмэлт, өөрчлөлт оруулах, гэрээг цуцлах

9.1. Гадаад, дотоод орчин өөрчлөгдсөнөөс гэрээг хэрэгжүүлэх боломжгүй болсон тохиолдолд хоёр тал бичгээр мэдэгдэж, харилцан зөвшилцөн гэрээнд нэмэлт, өөрчлөлт оруулж болно.

9.2. Гэрээний өөрчлөлтийг тухай бүрд нь бичгээр үйлдэн Захиалагч, Хэрэгжүүлэгч гарын үсэг зурж, гэрээний эх хувьд хавсаргана. Гэрээний анхны болон өөрчилсөн эхүүдийн хувь тус бүрийг Захиалагч болон Хэрэгжүүлэгч хадгална.

9.3. Гэрээнд тусгагдаагүй үйл ажиллагааг хэрэгжүүлэх асуудлыг талууд харилцан зөвшилцөж, нэмэлт гэрээ байгуулах замаар шийдвэрлэж болно. Ингэхдээ Захиалагчийн төсөвт өртгөөс давсан тохиолдолд Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.2-т заасан зарчмыг удирдлага болгон төсвийн тодотголоор шийдвэрлүүлэх арга хэмжээ авна.

9.4. Захиалагч гэрээний биелэлтийн үнэлгээний дүнг 2027 оны 03 дугаар сарын 01-ний дотор Засгийн газрын Хэрэг эрхлэх газарт хүргүүлнэ.

Арав. Талуудын хүлээх хариуцлага.

10.1. Гэрээний талууд энэхүү гэрээгээр хэрэгжүүлсэн үйл ажиллагааны үр дүнг Засгийн газрын өмнө хамтран хүлээнэ.

10.2. Гэрээний шалгуур үзүүлэлт хангасан тохиолдолд Захиалагчаас гүйцэтгэгчийг мөнгөн бус хэлбэрээр урамшуулна.

Арваннэг. Маргааныг шийдвэрлэх

11.1. Төлбөрийн шилжүүлэгтэй холбогдон үүссэн маргааныг Сангийн яаманд хандаж, зохицуулах арга хэмжээг авна.

11.2. Нийлүүлсэн бүтээгдэхүүний тоо хэмжээ, хугацаа, чанартай холбогдон үүссэн маргааныг гэрээний талууд зөвшилцөж шийдвэрлэхийг эрмэлзэнэ.

11.3. Зөвшилцөлд эс хүрвэл шүүхийн байгууллагад хандан шийдвэрлүүлнэ.

Арванхоёр. Гэрээ хүчин төгөлдөр болох

Энэхүү гэрээнд талууд гарын үсэг зурж, тамга (тэмдэг) дарж баталгаажуулснаар хүчин төгөлдөр болно.

Арвангурав. Гэрээний бүрэлдэхүүн хэсэг

13.1. Энэхүү гэрээ нь дараах бүрэлдэхүүн хэсгээс бүрдэнэ:

13.1.1. Монгол Улсын Эрүүл мэндийн сайд аймгийн Засаг даргатай 2025 онд хамтран ажиллах гэрээ;


13.1.2. Хавсралт 1. Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний чанарын үзүүлэлт;

13.1.3. Хавсралт 2. Аймгийн эрүүл мэндийн байгууллагуудын 2026 оны төсөв;

13.1.4. Хавсралт 3. 2026 онд улсын төсвийн хөрөнгөөр хэрэгжүүлэх хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээ, барилга байгууламжийн жагсаалт;

13.1.5. Хавсралт 5. Эрүүл мэндийн салбарт хэрэгжиж байгаа арга хэмжээний төлөвлөгөөнүүд;

ЗАХИАЛАГЧ:
ЭРҮҮЛ МЭНДИЙН САЙД,
ЭРҮҮЛ МЭНДИЙН ТӨСВИЙН
ЕРӨНХИЙЛӨН ЗАХИРАГЧ



Ж.ЧИНБҮРЭН

ХЭРЭГЖҮҮЛЭГЧ:
ОРХОН АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГА



Б.ЗОРИГТБАЯР

2026 оны 01 дүгээр сарын 15-ний өдөр
Улаанбаатар хот

Орхон аймгийн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний чанарын үзүүлэлт

Д/д	Үзүүлэлт	Суурь үзүүлэлт /2024 он/	Биеэлэлт /2025 он/	Хүрэх түвшин /2026 он/
1	Артерийн даралт ихсэх өвчний эрт илрүүлэлт хамрагдсан 18 ба түүнээс дээш насны хүн амын эзлэх хувь	74.1	82.2	84.0
2	Чихрийн шижин хэв шинж-2 өвчний эрт илрүүлэлт хамрагдсан 35 ба түүнээс дээш насны хүн амын эзлэх хувь	91.7	95.1	97.6
3	Хөхний өмөнгийн эрт илрүүлэлт хамрагдсан 30 ба түүнээс дээш насны эмэгтэйнүүдийн тоо	16626	18187	18740
4	Умайн хүзүүний өмөнгийн эрт илрүүлэлт хамрагдсан 30 ба түүнээс дээш насны эмэгтэйнүүдийн эзлэх хувь	41.3	33.0	33.9
5	Урьдчилан сэргийлэх үзлэгийн хувь	35.1	35.3	36.2
6	В вирус хепатитийн эсрэг сэргийлэх тарилгын 24 цагийн хамралтын хувь*	98.9	99.4	101.2
7	Тавт (сахуу, хөхүүл ханиад, татран, В хепатит, хамофилюсинфлюенза) сэргийлэх тарилгын хамралтын хувь /3-р тун*	99.8	99.9	102.0
8	Улаанбурхан-гахайн хавдар-улаануудын (УГУ) эсрэг сэргийлэх тарилгын хамралтын хувь /2-р тун*	99.9	99.8	101.6
9	Эхийн эндэгдлийн түвшин (100 000 амьд төрөлт тутамд)	0.0	0.0	0.0
10	Нялхсын эндэгдлийн түвшин (1000 амьд төрөлт тутамд)	9.9	7.7	7.5
11	Нарайн эндэгдлийн түвшин (1000 амьд төрөлт тутамд)	8.4	5.7	5.6
12	5 хүртэлх насны хүүхдийн эндэгдлийн түвшин (1000 амьд төрөлт тутамд)	10.4	8.3	8.1
13	Амьгүй төрөлтийн түвшин (1000 төрөлт тутамд)	4.0	4.6	4.5
14	Жирэмсний эхний 3 сард хяналтад орсон эхийн эзлэх хувь	99.2	99.0	101.1
15	Өсөөр насны 1000 эмэгтэйд ногдох төрөлтийн түвшин	7.5	8.0	7.8
16	Сүрьеэгийн өвчлөлийн түвшин, 10 000 хүн амд	9.3	7.1	6.9
17	Вирус хепатитын өвчлөлийн түвшин, 10 000 хүнд	0.4	0.4	0.4
18	Зүрх судасны өвчний шалтгаант нас баралтын түвшин, 10 000 хүнд	17.6	16.0	15.6
19	Хорт хавдарын шалтгаант нас баралтын түвшин, 10 000 хүнд	15.5	14.2	13.8
20	Амьс хорлож нас барсан тохиолдлын түвшин, 10 000 хүнд	0.3	0.2	0.2
21	Санамсаргүй хордох, хорт бодист өргөөнөөс шалтгаалсан нас баралтын түвшин, 10 000 хүнд /Х40-Х49/	1.6	2.3	2.2
22	0-5 насны хүүхдийн түлэгдэлтийн түвшин, (10 000 хүүхдэд, T20-T32)	12.2	15.5	15.1
23	Хүүхдийн зам тээврийн ослын шалтгаант нас баралтын түвшин, (10 000 хүүхдэд, V00-V99)	0.3	0.0	0.0
Нэмэлт				
24	Чихрийн шижингийн шалтгаант нас баралтын түвшин, 10000 хүнд	1.4	1.3	1.3
25	Амьсгалын замын архаг өвчний шалтгаант нас баралтын түвшин, 10000 хүнд	1.2	0.7	0.7
26	Сэргийлэх боломжтой эмнэлгийн бус нас баралтын нийт нас баралтад эзлэх хувь	59.6	55.8	54.4
27	Халдварт өвчний тохиолдлын тоо, 10000 хүнд	72.7	86.8	84.6
28	Бүх хэлбэрийн сүрьеэгийн эмчилгээний амжилтын хувь	94.6	79.6	89.6
29	Үр хөндлөлийн харьцаа, 1000 амьд төрөлтэд ногдох	105.6	148.2	143.9
30	Жирэмсний хугацаанд 6 ба түүнээс дээш удаа хяналтад хамрагдсан эмэгтэйнүүдийн хувь	79.2	93.8	96.2

Орхон аймгийн Эрүүл мэндийн газрын 2026 оны төсөв

/мянган төгрөг/

БАЙГУУЛЛАГА	2026 оны төсөв
Орхон	2,504,967.4
НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	2,504,967.4
УРСГАЛ ЗАРДАЛ	2,504,967.4
БАРАА, ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,353,097.1
Цалин, хөлс болон нэмэгдэл урамшил	1,073,281.3
Үндсэн цалин	615,409.6
Нэмэгдэл	263,872.7
Унаа хоолны Хөнгөлөлт	91,430.7
Урамшуулал	102,568.3
Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	134,160.1
Тэтгэврийн даатгал	91,228.9
Тэтгэмжийн даатгал	10,732.8
ҮОМШ-ний даатгал	5,366.4
Ажилгүйдлийн даатгал	5,366.4
Эрүүл мэндийн даатгал	21,465.6
Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	93,547.8
Гэрэл, цахилгаан	13,185.4
Түлш, халаалт	16,398.6
Цэвэр, бохир ус	19,323.0
Байрны түрээс	42,465.5
Хөрөнгийн ашиглалтын менежмент	2,175.3
Хангамж, бараа материалын зардал	21,244.9
Бичиг хэрэг	5,136.4
Тээвэр, шатахуун	8,541.0
Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	6,049.5
Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ар	561.8
Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	956.2
Нормативт зардал	409.3
Нормын хувцас, зөөлөн эдлэл	409.3
Эд хогшил, урсгал засварын зардал	6,152.6
Багаж, техник, хэрэгсэл	784.7
Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	952.9
Урсгал засвар	4,415.0
Томилголт, зочны зардал	6,848.5
Дотоод албан томилолт	6,848.5
Нийтлэг ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	10,165.1
Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	365.0
Даатгалын үйлчилгээ	599.8
Тээврийн хэрэгслийн татвар, оношилгоо	126.6
Мэдээллийн технологийн үйлчилгээ	6,848.5
Нийтлэг үйлчилгээний төлбөр, хураамж	848.0

Хувийн хэвшилээр гүйцэтгүүлэх үйлчилгээ	1,377.2
Бараа үйлчилгээний бусад зардал	7,287.5
Бараа үйлчилгээний бусад зардал	5,346.7
Сургалт, дадлага, бэлтгэлийн зардал	1,940.8
УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	1,151,870.3
Бусад урсгал шилжүүлэг	1,151,870.3
Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	405,398.5
Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан а	746,215.0
Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	256.8
ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	2,504,967.4
Улсын төсвөөс санхүүжих	2,504,967.4
Улсын төсвөөс санхүүжих	2,504,967.4
ТӨСВИЙН БУСАД МЭДЭЭЛЛИЙН АНГИЛАЛ	100.0
БАЙГУУЛЛАГЫН ТОО	1.0
Төсвийн байгууллага	1.0
АЖИЛЛАГСДЫН ТОО	37.0
Удирдах ажилтан	1.0
Гүйцэтгэх ажилтан	33.0
Үйлчлэх ажилтан	3.0
ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ	37.0
Төрийн захиргааны албан хаагч (ТЗ)	26.0
Эрүүл мэндийн салбарын төрийн үйлчилгээний албан	4.0
Төрийн нийтлэг үйлчилгээний албан хаагч (ТҮ)	5.0
Төрийн үйлчилгээний мэргэжлийн (ТҮМ)	2.0
НИЙТ ТЭТГЭВЭРТ ГАРАГЧ	25.0
Төрийн албаны тухай хуулиар тэтгэвэрт гарагч	25.0
Эрүүл мэндийн газар	2,504,967.4
НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	2,504,967.4
УРСГАЛ ЗАРДАЛ	2,504,967.4
БАРАА, ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,353,097.1
Цалин, хөлс болон нэмэгдэл урамшил	1,073,281.3
Үндсэн цалин	615,409.6
Нэмэгдэл	263,872.7
Унаа хоолны Хөнгөлөлт	91,430.7
Урамшуулал	102,568.3
Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	134,160.1
Тэтгэврийн даатгал	91,228.9
Тэтгэмжийн даатгал	10,732.8
ҮОМШ-ний даатгал	5,366.4
Ажилгүйдлийн даатгал	5,366.4
Эрүүл мэндийн даатгал	21,465.6
Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	93,547.8
Гэрэл, цахилгаан	13,185.4
Түлш, халаалт	16,398.6
Цэвэр, бохир ус	19,323.0
Байрны түрээс	42,465.5
Хөрөнгийн ашиглалтын менежмент	2,175.3
Хангамж, бараа материалын зардал	21,244.9
Бичиг хэрэг	5,136.4

Тээвэр, шатахуун	8,541.0
Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	6,049.5
Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн уст	561.8
Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	956.2
Нормативт зардал	409.3
Нормын хувцас, зөөлөн эдлэл	409.3
Эд хогшил, урсгал засварын зардал	6,152.6
Багаж, техник, хэрэгсэл	784.7
Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	952.9
Урсгал засвар	4,415.0
Томилголт, зочны зардал	6,848.5
Дотоод албан томилголт	6,848.5
Нийтлэг ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	10,165.1
Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	365.0
Даатгалын үйлчилгээ	599.8
Тээврийн хэрэгслийн татвар, оношилгоо	126.6
Мэдээллийн технологийн үйлчилгээ	6,848.5
Нийтлэг үйлчилгээний төлбөр, хураамж	848.0
Хувийн хэвшлээр гүйцэтгүүлэх үйлчилгээ	1,377.2
Бараа үйлчилгээний бусад зардал	7,287.5
Бараа үйлчилгээний бусад зардал	5,346.7
Сургалт, дадлага, бэлтгэлийн зардал	1,940.8
УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	1,151,870.3
Бусад урсгал шилжүүлэг	1,151,870.3
Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн т	405,398.5
Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажил	746,215.0
Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	256.8
ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	2,504,967.4
Улсын төсвөөс санхүүжих	2,504,967.4
Улсын төсвөөс санхүүжих	2,504,967.4
ТӨСВИЙН БУСАД МЭДЭЭЛЛИЙН АНГИЛАЛ	100.0
БАЙГУУЛЛАГЫН ТОО	1.0
Төсвийн байгууллага	1.0
АЖИЛЛАГСДЫН ТОО	37.0
Удирдах ажилтан	1.0
Гүйцэтгэх ажилтан	33.0
Үйлчлэх ажилтан	3.0
ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ	37.0
Төрийн захиргааны албан хаагч (ТЗ)	26.0
Эрүүл мэндийн салбарын төрийн үйлчилгээни	4.0
Төрийн нийтлэг үйлчилгээний албан хаагч (ТҮ)	5.0
Төрийн үйлчилгээний мэргэжлийн (ТҮМ)	2.0
НИЙТ ТЭТГЭВЭРТ ГАРАГЧ	25.0
Төрийн албаны тухай хуулиар тэтгэвэрт гарг	25.0
Үндсэн үйл ажиллагааны зардал	1,347,287.2
НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	1,347,287.2
УРСГАЛ ЗАРДАЛ	1,347,287.2
БАРАА, ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,347,287.2
Цалин, хөлс болон нэмэгдэл урамшил	1,073,281.3

Үндсэн цалин	615,409.6
Нэмэгдэл	263,872.7
Унаа хоолны Хөнгөлөлт	91,430.7
Урамшуулал	102,568.3
Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтг	134,160.1
Тэтгэврийн даатгал	91,228.9
Тэтгэмжийн даатгал	10,732.8
ҮОМШ-ний даатгал	5,366.4
Ажилгүйдлийн даатгал	5,366.4
Эрүүл мэндийн даатгал	21,465.6
Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	91,372.5
Гэрэл, цахилгаан	13,185.4
Түлш, халаалт	16,398.6
Цэвэр, бохир ус	19,323.0
Байрны түрээс	42,465.5
Хангамж, бараа материалын зардал	21,244.9
Бичиг хэрэг	5,136.4
Тээвэр, шатахуун	8,541.0
Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	6,049.5
Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн	561.8
Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйл	956.2
Нормативт зардал	409.3
Нормын хувцас, зөөлөн эдлэл	409.3
Эд хогшил, урсгал засварын зардал	6,152.6
Багаж, техник, хэрэгсэл	784.7
Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	952.9
Урсгал засвар	4,415.0
Томилолт, зочны зардал	6,848.5
Дотоод албан томилолт	6,848.5
Нийтлэг ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	10,165.1
Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	365.0
Даатгалын үйлчилгээ	599.8
Тээврийн хэрэгслийн татвар, оношилгоо	128.6
Мэдээллийн технологийн үйлчилгээ	6,848.5
Нийтлэг үйлчилгээний төлбөр, хураамж	848.0
Хувийн хэвшилээр гүйцэтгүүлэх үйлчилгээ	1,377.2
Бараа үйлчилгээний бусад зардал	3,652.9
Бараа үйлчилгээний бусад зардал	1,712.1
Сургалт, дадлага, бэлтгэлийн зардал	1,940.8
ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	1,347,287.2
Улсын төсвөөс санхүүжих	1,347,287.2
Улсын төсвөөс санхүүжих	1,347,287.2
ТӨСВИЙН БУСАД МЭДЭЭЛЛИЙН АНГИЛАЛ	75.0
БАЙГУУЛЛАГЫН ТОО	1.0
Төсвийн байгууллага	1.0
АЖИЛЛАГСДЫН ТОО	37.0
Удирдах ажилтан	1.0
Гүйцэтгэх ажилтан	33.0
Үйлчлэх ажилтан	3.0

ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ	37.0
Төрийн захиргааны албан хаагч (ТЗ)	26.0
Эрүүл мэндийн салбарын төрийн үйлчилгээ	4.0
Төрийн нийтлэг үйлчилгээний албан хаагч	5.0
Төрийн үйлчилгээний мэргэжлийн (ТҮМ)	2.0
Харуул, хамгаалалтын зардал	2,175.3
НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	2,175.3
УРСГАЛ ЗАРДАЛ	2,175.3
БАРАА, ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	2,175.3
Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	2,175.3
Хөрөнгийн ашиглалтын менежмент	2,175.3
ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	2,175.3
Улсын төсвөөс санхүүжих	2,175.3
Улсын төсвөөс санхүүжих	2,175.3
Ажил олгогчоос олгох тэтгэмж, урамшуулал, дэмжлэг	1,151,870.3
НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	1,151,870.3
УРСГАЛ ЗАРДАЛ	1,151,870.3
УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	1,151,870.3
Бусад урсгал шилжүүлэг	1,151,870.3
Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгө	405,398.5
Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай аж	746,215.0
Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	256.8
ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	1,151,870.3
Улсын төсвөөс санхүүжих	1,151,870.3
Улсын төсвөөс санхүүжих	1,151,870.3
ТӨСВИЙН БУСАД МЭДЭЭЛЛИЙН АНГИЛАЛ	25.0
НИЙТ ТЭТГЭВЭРТ ГАРАГЧ	25.0
Төрийн албаны тухай хуулиар тэтгэвэрт га	25.0
Хөтөлбөр төслийн дотоод урсгал зардал	3,634.6
НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	3,634.6
УРСГАЛ ЗАРДАЛ	3,634.6
БАРАА, ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	3,634.6
Бараа үйлчилгээний бусад зардал	3,634.6
Бараа үйлчилгээний бусад зардал	3,634.6
ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	3,634.6
Улсын төсвөөс санхүүжих	3,634.6
Улсын төсвөөс санхүүжих	3,634.6

Эрүүл мэндийн салбарт хэрэгжиж байгаа арга хэмжээний төлөвлөгөө:

1. Эрүүл шүд арга хэмжээний төлөвлөгөө (2024-2027) батлах тухай Эрүүл мэндийн сайд боловсрол, шинжлэх ухааны сайдын хамтарсан тушаал 2024.01.19 А/27/А/25 дугаар тушаал.
2. Эрүүл настан, идэвхитэй насжилтыг дэмжих арга хэмжээний төлөвлөгөө (2025-2028) Эрүүл мэндийн сайд, гэр бүл, хөдөлмөр, нигмийн хамгааллын сайдын хамтарсан тушаал. 2025.10.03 А/366/А/191 дугаар тушаал.
3. Иргэний эрүүл мэндийн боловсролыг дээшлүүлэх арга хэмжээний төлөвлөгөө (2024-2027). Эрүүл мэндийн сайд, Монгол Улсын сайд, Олимп, нийтийн биеийн тамир, спортын үндэсний хорооны дарга, Боловсрол, шинжлэх ухааны сайд, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын хамтарсан тушаал. 2024.02.02 А/75, А/09, А/73, А/34 дугаар тушаал.
4. Сэтгэцийн эрүүл мэндийн арга хэмжээний төлөвлөгөө (2024-2027). Эрүүл мэндийн сайдын 2024.03.29 А/148 дугаар тушаал.
5. Жендерт суурилсан болон гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх, сэргийлэх арга хэмжээний төлөвлөгөө (2024-2027). 2024.03.05 А/111 дугаар тушаал.
6. Халдварт өвчинтэй тэмцэх, сэргийлэх арга хэмжээний төлөвлөгөө (2022-2025) 2022.10.31. А/528 дугаар тушаал
7. Элэг бүтэн Монгол арга хэмжээний төлөвлөгөө (2022-2025). 2022.12.05. А/577 дугаар тушаал.

Эрүүл мэндийн салбарт 2025 онд батлагдсан арга хэмжээний төлөвлөгөөнууд:

8. Хорт хавдраас сэргийлэх, хянах хөтөлбөр. (2025-2028). Эрүүл мэндийн сайдын 2025.06.12 А/241 дугаар тушаал
9. Эрүүл мэндийн салбарын дижитал шилжилтийн цогц арга хэмжээний төлөвлөгөө. (2024-2028). Эрүүл мэндийн сайд, цахим хөгжил, инноваци, харилцаа холбооны сайдын 2025.05.22 А/201/ А/81 дугаар тушаал
10. Эх баригчийн хөгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө. (2025-2028). Эрүүл мэндийн сайдын 2025.07.09 А/264 тоот тушаал
11. Эх, хүүхэд, нөхөн үржихүйн эрүүл мэнд арга хэмжээний төлөвлөгөө (2025-2028). Эрүүл мэндийн сайдын 2025.05.30 А/219 дугаар тушаал
12. Эрүүл мэндийн салбарт хүний нөөцийн хөгжлийг дэмжих арга хэмжээний төлөвлөгөө. (2025-2028). Эрүүл мэндийн сайдын 2025.10.10 А/379 дугаар тушаал

13. Анагаах ухааны салбарт хиймэл оюун ухааныг нэвтрүүлэх арга хэмжээ. (2026-2027). Эрүүл мэндийн сайдын 2025.11.20 А/434 дугаар тушаал
14. Эрүүл мэндийн тусламж үйлчилгээний төвлөрлийг сааруулах талаар авах арга хэмжээ. Эрүүл мэндийн сайдын 2025.05.150 А/195 дугаар тушаал
15. Эрэгтэйчүүдийн эрүүл мэнд арга хэмжээний төлөвлөгөө 2025-2028. Эрүүл мэндийн сайдын 2025.11.18. А/424 дүгээр тушаал
16. Сүрьеэтэй тэмцэх, сэргийлэх, арга хэмжээний төлөвлөгөө (2025-2028). Эрүүл мэндийн сайдын 2025.08.28. А/319 дүгээр тушаал
17. Эрүүл, аюулгүй сургууль арга хэмжээний төлөвлөгөө (2025-2028) Боловсролын сайд, Эрүүл мэндийн сайдын 2025.02.06 А/53, А/37 дугаар тушаал
18. Орчны эрүүл мэнд арга хэмжээний төлөвлөгөө /2025-2028/ Эрүүл мэндийн сайдын 2025.12.10 А/465 дугаар тушаал гэх мэт арга хэмжээг хэрэгжүүлж шаардлагатай санхүүжилт, бодлогын дэмжлэгийг үзүүлж, хэрэгжилтэнд хяналт тавьж ажиллана.